Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АРТБАЗАРЫН БАЯРЗАЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. ЗОРИЛТ 2. **ЗГҮАХ 2.1.13.1 ТЭМТББ 2.4.2.2** Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ. | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1.** Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам боловсруулж батлуулна. | ЭМС-ын сайдын тушаал | Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам боловсруулж байна | Сайдын тушаал боловсруулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/122 дугаар “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам батлах тухай” тушаал батлагдсан. | 03 | 100% |
| 2 | **Арга хэмжээ 1.2.** Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм боловсруулж батлуулна. | ЭМС-ын сайдын тушаал | Өрхийн эрүүл мэндийн дүрмийг боловсруулж байна | Сайдын тушаал боловсруулж батлуулсан байна. | “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм” ЭМС-ын 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А/321 дугаар тушаалаар батлагдсан. | 03 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3 | **Арга хэмжээ 1.3.** Өрхийн эрүүл мэндийн сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж батлуулна. | ЭМС-ын сайдын тушаал | | Сайдын тушаал боловсруулж батлуулсан байна. | "Өрхийн эрүүл мэндийн сонгон шалгаруулах журам" ЭМС-ын 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А/320 дугаар тушаалаар батлагдсан. | 06 | 100% |
| ХОЁР. "АНХАН БОЛОН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД<br>**Хүн амд үзүүлэх эмнэлгийн лавлагаа болон анхан шатны тусламж, үйлчилгээний бодлого, эрхзүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд** | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 2.1.** Багийн эмчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах тухай арга хэмжээ авна | ЭМ-ийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын "Жагсаалт батлах тухай" 2008 оны 26 дугаар, 2020 оны 291 дүгээр тушаал | Сайдын тушаал боловруулж батлуулсан байна | ЭМС-ын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн "Багийн эмчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах тухай" А/24 дугаар тушаал батлагдсан. | 01 | 100% |
| 2 | **Арга хэмжээ 2.2.** Багийн эмчийн тусламж, үйлчилгээнд хэрэгэлэх багцаар хангах | ЭМ-ийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын "Жагсаалт батлах тухай" 2008 оны 26 дугаар, 2020 оны 291 дүгээр тушаал | Сайдын тушаал боловруулж батлуулсан байна | ЭМС-ын 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А/103 дугаар тушаалаар 1861 багийн баг эмчид "Багийн эмчийн үзлэгийн багцын тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслэл" хуваарилсан. | 01 | 100% |
| 3 | **Арга хэмжээ 2.3.** Өрхийн эрүүл мэндийн төвийн | Шинэчлэн батлуулсан стандарт | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, | Өрхийн эрүүл мэндийн төвийн стандартын | Өрхийн эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн тушаал батлагдах шатандаа байна. | 07 | 30% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | стандартыг шинэчлэн боловсруулж стандартын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлнэ. | | үйл ажиллагаа MNS 5292:2017 | шинэчлэн батлуулсан байна. | | | |
| 4 | **Арга хэмжээ 2.4.** Сумын эрүүл мэндийн төвийн стандартыг батлуулна | Шинэчлэн батлуулсан стандарт | Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5081:2013 | Сумын эрүүл мэндийн төвийн стандартын шинэчлэн батлуулсан байна. | Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төслийг шинэчлэн боловсруулсан . | 05 | 40% |
| ГУРАВ. ЗГҮАХ 2.1.6.“ЦАХИМ МОНГОЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЖ, ОРОН НУТАГТ ХИЙГДЭХ ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНД АЛСЫН ЗАЙН ТЕХНОЛОГИ АШИГЛАН, ЦАХИМ ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ЭРГЭН ДУУДАХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 3.1** ЗГҮАХ 2.1.6.8 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ. | Мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоо | 2023 онд 218 сумын эрүүл мэндийн төв, 105 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн. | | Тайлант хугацаанд нийт 57 сумын эрүүл мэндийн төв, нийслэлийн 17 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээний багцын тоног, төхөөрөмжийг ЭМС-ын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 246 дугаар тушаалаар хуваарилсан. 2024 оны 10-11 сард нийт 74 Мобайлын тоног төхөөрөмжүүдийг холбогдох мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх 3 өдрийн цогц сургалтыг нийт 12 аймаг, 4 дүүргийн 152 хүнд зохион байгуулсан. | 06 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 30 ДУГААР ЗҮЙЛИЙН 1 ДЭХ ХЭСГИЙГ ҮНДЭСЛЭН ""АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 52 ДУГААР ТОГТООЛЫН 2 ДУГААР ХАВСРАЛТЫН 2.2.31, 2.2.32 ДАХЬ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ<br>"Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-ний хүрээнд | | | | | | | |
| | **Арга хэмжээ 4.1**<br><br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнийг ажиллах үзлэгийн өрөө эсвэл буланг тохижуулах | Хамтран ажилласан үйл ажиллагааны тайлан, өгсөн саналын тоо | Байхгүй | | Анхан шатны эрүүл мэндийн 15 байгууллагад шүд, амны хөндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнийг ажиллах нөхцлийг бүрдүүлсэн. | 03 | 15% |
| ТАВ. ЭРҮҮЛ МЭНД. ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, ОРЧИН ҮЕИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИЙГ ӨРГӨЖҮҮЛЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 5.1**<br><br>МУТЖҮЧ 2.2.2<br><br>Хүн амын зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс Монгол Улсын хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулсан. | | 1. 2021 оны Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээний лабораторийн 5 төрлийн шинжилгээний үр дүнг боловсруулах, үзүүлэлт түс бүрээр дүгнэлт гаргах, судалгааны ажилд оролцсон. | 12 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | 2. Зүрх судасны өвчний нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг 7 аймаг, Улаанбаатар хотын 8 дүүрэгт нэвтрүүлж хэрэгжүүлэх техникийн ажлын хэсгийн 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ЭМС-ын 414 дугаар тушаалаар томилогдон ажлын хэсэгт ажиллаж байна. | | |
| 2 | **Арга хэмжээ 5.2**<br><br>УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1<br>ЗГҮАХ 2.1.1.5<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.15<br>“Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 оны арга хэмжээний хэрэгжилт 54.3 хувьд хүрсэн. | 18-аас дээш насны хүн амын 90 хувь нь элэгний өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөнд туссан эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 10 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсны 6 арга хэмжээ-100%, 2 арга хэмжээ -50%%, 2 арга хэмжээ 30%, 1 арга хэмжээ 0%-ийн дундаж хэрэгжилтийн хувь 78 болгон нэмэгдүүллээ<br>Зохион байгуулсан үйл ажиллагааг тодруулбал,<br>• Эрүүл мэндийн сайдын 2023 оны 7 дугаар сарын 5-ны А/250 тоот тушаалаар булевиртид эмийг “Өнчин эмийн жагсаалт”-д бүртгэж, Монгол Улсад эмчилгээнд нэвтрүүлэх, эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>• Гепатитын D вирусийн халдвартай иргэдэд урсофальк эмийг хөнгөлөлттэй үнээр олгох тоо хэмжээг 2 дахин нэмэгдүүллээ. | 01 | 60% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | • Оношилгоо шинжилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор ХӨСҮТ-ийн лабораторид 30 гаруй нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг суурилуулж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын гепатитын B, D вирусийн халдварыг илрүүлэх, ачаалал тодорхойлох шинжилгээнд зарцуулах санхүүжилтийг нэмж хуваарилсан.<br>• “Гепатитын B, D вирусийн шалтгаант архаг үрэвслийн үед D вирусийн эсрэг булевиртид эмчилгээг хийж байх хугацаанд болон гепатитын B, D вирусийн шалтгаант элгэний циррозын Чайлд-Пьюгийн ангилалд үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг нэмэгдүүлсэн шийдвэрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран гаргасан.<br>• Эмнэлгийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ХӨСҮТ-ийн амбулаторийн тасагт гепатитын B, D вирусийн халдвартай иргэдэд үйлчлэх хэсгийг өргөжүүлэн шинээр кабинет нээж, үйл ажиллагаа нь эхлүүлсэн.<br>• Эрүүл мэндийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам, заавар батлах тухай” тушаалын дагуу А/18 дугаар тушаалаар “Гепатитыгн B, C, D вирусийн эмнэлзүйн заавар” баталж эрхзүйн орчинг шинэчиллээ. | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | • Эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах хүрээнд 21 аймаг 9 дүүргийн 400 гаруй эмч, мэргэжилтнүүдэд танхим болон цахим сургалт зохион байгуулсан.<br>• Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 04 тогтоолыг батлуулсан. Тус тогтоолоор "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, D вируст гепатитын халдвартай иргэдийн эмчилгээний зардлыг шийдвэрлэх чиглэл өгсөн.<br>• Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улс хооронд өр хөрвүүлэх хэлэлцээр хийж, үүний үр дүнд Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг Глобаль Сангаар дамжуулан хэрэгжүүлэх төслийг боловсруулан Глобал Сангийн түхникийн хороонд хүргүүлсэн. | | |
| 3 | **Арга хэмжээ 5.3**<br><br>ЗГҮАХ 2.1.1.4<br><br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.5 "Хавдрын эсрэг" арга хэмжээг | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | | Тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бууруулах, төвлөрлийг сааруулах "үндэсний баг" 2024 оны 09 дүгээр сараас "Хавдрын эсрэг" арга хэмжээг эхлүүлж Хэнтий аймагт 2 удаа, Өмнөговь аймагт 2 удаа, Өвөрхангай, Орхон аймагт тус тус 1 удаа ажиллаж, нийт | 03 | 40% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулна. | | | | 1248 хүний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулсан. | | |
| 4 | **Арга хэмжээ 5.4**<br><br>ЗГҮАХ 2.1.2.2 Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна. | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | Эмчилгээнд хамрагдсан хувь Санхүүжил-тийн хэмжээ | | Гепатитын Д вирустай иргэдийн оношилгоо, эмчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авсан:<br>1. Гепатитын D вирусийг эсрэг Булевиртид (Heptulex) эмийг үйлдвэрлэгч АНУ-ын Gilead Science компаниас 2024-2025 онд шууд худалдан авах тухай гэрээ байгуулав.<br>2. Одоогоор гепатитын B, D вирусийн эмчилгээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа вирусийн эсрэг эмчилгээнд зарцуулах санхүүжилтийг шийдвэрлэж, халдварт өвчний үндэсний лавлагаа төв иргэдийг эмчилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай ЭМС-ын 2024 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/272 дугаар тушаалаар батлав.<br>3. АНУ-ын Гилеад Сайенс компанийн үйлдвэрлэсэн Булевиртид (Hepcludex) тариаг худалдан авч 136 хүнийг, ПЭГ-интерферон эмчилгээнд 239 хүнийг | 01 | 80% |

15

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд хамруулсан байна. ПЭГ-интерферон эмчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн 31 хувийг 30-39 нас, 41 хувийг 40-49 нас, 21 хувийг 50-59 насныхан эзэлж байгаагаас 11 хүн аймаг, орон нутгаас байна. Харин Булевиртид (Hepcludex) эмчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн 23 хувийг 30-39 нас, 32 хувийг 40-49 нас, 29 хувийг 50-59 насныхан эзэлж байна. | | |
| 5 | **Арга хэмжээ 5.5** ЗГҮАХ 2.1.1.6 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.6 "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | . | Санал өгсөн байна. | 03 | 0% |
| 6 | **Арга хэмжээ 5.6** ЗГҮАХ 2.1.13.3 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний | Үнэлгээний тайлан | - | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагатай гэрээ хийж, үнэлгээ хийгдсэн байна. | 1. "Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь" төслийг Монгол улсад 2016 оноос эхэлж, төслийн үр дүнг ЭМАШТҮ үзүүлэгч эмч нарын хүн төвтэй тусламж үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар, хандлага; мобайл технологийн ашиглалтын өнөөгийн байдал; тусламж үйлчилгээн дэх мобайл технологийн хэрэглээ ба хамралтын түвшин; VHS | 03 | 100% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно. | | | | програмын мэдлэг, чадвар, хандлага гэсэн чиглэлээр АШУИС-ийн НЭМС-ийн дэргэдэх НЭМ-ийн хүрээлэнгийн үнэлгээний баг хийж ЭМЯ-нд танилцуулсан. Энэхүү үнэлгээнд хамрагдсан эмч нарын хүн төвтэй ЭМАШТҮ үзүүлэх мэдлэгийн дундаж түвшин 87 хувь, зэрэг хандлагын түвшин дунджаар 91 хувь, дадал 83 хувь байна.<br>Үнэлгээнд хамрагдсан ЭМАШТҮ үзүүлэгч байгууллагуудын мобайл технологи (мобайл ЭХО, ЭКГ, даралтын аппарат), түргэвчилсэн сорил (глюкоз, холестерин, гепатит В, С, тэмбүү, ХДХВ/ДОХ, хеликобактер), бусад шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг (биеийн жин, өндөр хэмжигч) тусламж үйлчилгээнд, тухайлбал урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт хангалттай сайн ашигладаг байна. Судалгаанд оролцогч эмч нарын 78 хувь нь мобайл технологийг ашиглах хангалттай мэдлэг, туршлагатай байна.<br>1. “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн судалгаа” АШУИС-ийн НЭМС-ийн дэргэдэх НЭМ-ийн хүрээлэнгийн үнэлгээний баг хийсэн.<br><br>ДҮГНЭЛТ<br>1. Иргэд ЭМАШТҮ үзүүлэгч байгууллагад хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, эмийн | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | жор бичүүлэх, амбулаторийн тусламж үйлчилгээ, яаралтай үеийн тусламж үйлчилгээ,<br>ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээ авахаар хамгийн их ханддаг байна.<br>ЭМТ-үүдэд хандаж буй давтамжийн хувьд нийт үйлчлүүлэгчдийн гуравны хоёр нь сард нэг удаа болон гурван сард нэг удаа үйлчлүүлдэг байна. ЭМТ-үүдэд хандах давтамж нь сумын ЭМТ болон сум дундын эмнэлгээр үйлчлүүлэгчдийн давтамж Улаанбаатар хотын өрхийн ЭМТ-өөр үйлчлүүлэгчидтэй харьцуулахад бага байв.<br>2. ЭМАШТҮ-ний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд буюу 3.06 оноо (хамгийн ихдээ 5 оноо) байв. Эмэгтэй үйлчлүүлэгчид болон 60-аас дээш насны ахмадууд ЭМТ-үүдийн үзүүлж буй анхан шатны тусламж үйлчилгээнд илүү сэтгэл ханамжтай байдаг байна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж хотын болон аймгийн төвийн өрхийн ЭМТ-үүдийн хувьд ижил түвшинд байлаа. Нэгдүгээр зэрэглэлийн сумын ЭМТ-өөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хоёр ба гуравдугаар зэрэглэлийн сумын ЭМТ-ийн үйлчлүүлэгчдийнхээс харьцангуй өндөр байв. | | |
| ЗУРГАА. САЙД, ДЭД САЙД, УДИРДЛАГА БОЛОН ЯАМНЫ АППАРАТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛНЭ | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 6.1 Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлт боловсруулж, санал хүргүүлсэн байна.** | Саналын тоо, эрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | Санал боловсруулсан байна | | 03 | 0% |
| 2 | **Арга хэмжээ 6.2** Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж санал хүргүүлсэн байна. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | | | 1. Арга хэмжээ -4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж санал авах уулзалт хэлэцүүлгийг хяналт, үнэлгээний арга хэмжээг Говь-алтай аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн эрүүл мэндийн анхан шатны байгууллагын уулзалт, Багийн эмч нарын зөвлөгөөн, саналыг авч боловсруулж, тушаалын төсөлд санал өгөхөд бэлэн болгосон.<br>2. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001 стандартын шаардлагыг хангаж 2024 онд шинээр 10 өрхийн эрүүл мэндийн төв гэрчилгээ авсан: Баянзүрх дүүргийн 26-р хорооны Тэгшдүүрэн хүслэн ӨЭМТ, Сонгинохайрхан дүүргийн 19-р хорооны Батцэцэн ӨЭМТ, 15,30-р хорооны Мичид Асрал ӨЭМТ, 12, 13-р хорооны Алтанцэгцүүхэй ӨЭМТ, Сүхбаатар дүүргийн 8-р хорооны Манай эмч ӨЭМТ, 10-р хорооны Энэр-Ази ӨЭМТ, 15-р хорооны Гүн мэдрэмж ӨЭМТ, 16-р хорооны Мандам ӨЭМТ, БГД-ийн 5-р хорооны Дэшигдун ӨЭМТ, 3-р хорооны Ангирмаа ӨЭМТ, нийт. | 03 | 20% |
| ДОЛОО. 2.3. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 7.1** Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг /2024-2027/ хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр төлөвлөгдсөн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | | **Нийт арга хэмжээний 20%** | Нийт -4 арга хэмжээ. 2024 оны 9 дүгээр сарын 5-6-ны өдрийн Глобал сангийн дэмжлэгтэйгээр “Сүрьеэгүй эрүүл мэндийн төлөө хамтдаа” зүүн бүсийн СЭМТ-ийн багийн эмч, лаборант нарын сургалт, 10 дугаар сарын 12-13-ны өдрийн “Сүрьеэгүй эрүүл мэндийн төлөө хамтдаа”өмнөд бүсийн СЭМТ-ийн багийн эмч, лаборант нарын сургалт, 10 дугаар сарын 11-12 өдрийн “Өрхийн эрүүл мэндийн төвд сүрьеэгийн тусламж, үйлчилгээг бэхжүүлэх” эмч нарын сургалт,10 дугаар сарын 18-ны өдрийн ”Зүрх судасны эрсдэлийн анхан шатны тусламж, үйлчилгээнд тодорхойлох” | 03 | 60% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ний биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | “Сэргийлэх боломжтой эхийн болон перинатал эндэгдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх, 2022-2027” төслийн хүрээнд СЭМТ-д тетлемедицины тоног төхөөрөмж хуваарилах | ЭМС-ын тушаал батлагдсан | | | ЭМС-ын 2024 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн “Тоног төхөөрөмжийг орлогод авч, хуваарилах, үндсэн хөрөнгөд бүртгэх тухай” А/159 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам хамтран хэрэгжүүлж буй Люксембургийн Их Гүнт улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сангийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Сэргийлэх боломжтой эхийн болон перинатал эндэгдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх, 2022-2027” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 127,534,000 (нэг зуун хорин долоон сая таван зуун гучин дөрвөн мянга) төгрөгийн үнэ бүхий телемедицины | 03 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | тоног төхөөрөмжийг 20 СЭМТ, 2 ӨЭМТ-д хуваарилж хүргүүлэв. | | |
| 2 | “Лабораторийн чанарын баталгаажуулалтын тушаал”-ыг шинэчлэн батлуулах | ЭМС-ын тушаал батлагдсан | | | 1. Лабораторийн шинжилгээний дотоод болон гадаад хяналтын тогтолцоог бэхжүүлэх, шинжилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах зорилгоор 2007 онд Эрүүл мэндийн сайдын 299 тоот “Лавлах шинжилгээ, чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулах тухай” тушаал батлагдсан. Тус тушаалын дагуу УГТЭ, ХӨСҮТ, Анагаах ухааны хүрээлэн, ЦССҮТ-ийн лабораториуд тодорхой шинжилгээний лавлагаа, чанарын баталгаажуулалт, гадаад хяналт хийх чиглэл авсан. Мөн Монгол Улсад шинжилгээний чанарын гадаад үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам, Японы Сисмекс корпорацтай 2008 оны 6-р сард хамтын ажиллагааны гэрээ байгуулж, гэрээг 6 удаа сунгаж, 16 жил хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Сисмекс корпорацын зүгээс гематологи, биохими, иммунологи, цусны бүлэгнэлт, иммуногематологи, цусны эсийн түрхэц, шээсний шинжилгээний үндэсний чанарын гадаад хяналт явуулахад улсын болон | 10 | 90% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хувийн хэвшлийн лабораторийн эмч, мэргэжилтнээс бүрдсэн үндэсний багийг мэргэшүүлэх, лавлагаа лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан хяналтын материалаар хангах, чанарын гадаад хяналтыг тасралтгүй зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ирсэн. Үүний үр дүнд нийт оролцогч лабораторийн тоо 230 хүрсэн байна.<br>Цаашид чанарын гадаад хяналтын лавлагаа лабораториудын үүрэг, чиглэлийг шинэчилж орон нутгийн гадаад хяналтын сүлжээ, тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байгаа тул ЭМС-ын 2007 оны А/299 дугаар тушаалыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага гарсан.<br>Шинэчилсэн тушаал батлагдах шатандаа явж байна.<br>2. Япон Улсын Сисмекс корпорацын Япон, Азийг хариуцсан дэд ерөнхийлөгч К.Кавахараг ЭМС-тай 2024 11 дүгээр сарын 27-нд хийсэн уулзалтыг зохион байгуулж, гэрээний хэрэгжиллт, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, лавлагаа лабораторийн төсөл дээр | | |

52

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хамтран ажиллах боломжийг судлан хэлэлцэхээр тохиролцов. | | |
| 3 | Төвлөрлийг сааруулах “үндэсний баг”-ийн үйл ажиллагааг зохион байгуулах | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | | | 1. Тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бууруулах, төвлөрлийг сааруулах чиглэлээр Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/367 дугаар тушаалаар “үндэсний баг”-ийг байгуулан, орон нутгийн эмнэлгийн хүний нөөцийг чадавхжуулах, эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. 2024 оны 09 дүгээр сарын байдлаар Хавдар, ангиографийн үндэсний баг Хэнтий аймагт 2 удаа, Өмнөговь аймагт 2 удаа, Өвөрхангай, Орхон аймагт тус тус 1 удаа ажиллаж, нийт 1039 хүнд амбулаторийн үзлэг хийж, 36 хүнд хавдрын ангиографийн эмчилгээ хийж, 158 хүнийг зүрх, тархины судсанд дотуурх оношилгоо, 73 хүнийг судсанд дотуурх эмчилгээнд хамруулж, хавдрын хими эмчилгээнд 48 хүн, хавдрын мэс засалд 15 хүн орсон байна. Мөн үндэсний баг орон нутагт ажиллах хугацаандаа эмч, мэргэжилтнүүдэд зориулан хавдар судлал, мэс засал, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ, хими эмчилгээ сэдвээр ажлын байран дээрх 30 удаагийн сургалтыг зохион байгуулсан.<br>2. Төвлөрлийг сааруулах зорилгоор Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Дорнод | 09 | 70% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | аймгийн БОЭТ-ийн хавдрын үзлэг, оношилгоо, эмчилгээ, мэс засал, зүрх, мэдрэл, эмэгтэйчүүдийн ангиографи, зүрхний хэм алдагдал, гэмтлийн тусламж, үйлчилгээг нутагшуулах зорилгоор тус аймгуудын хүний нөөц, тоног, төхөөрөмжийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж мэргэшүүлэх шаардлагатай хүний нөөц, шинээр авах тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан. | | |
| 4 | | | | | 3. | | |

**Гурав . Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинээч бэлтгэх, чадавхжуулах богино хугацааны сургалтад хамрагдсан | | Суралцсан кредит цаг | Сургалтад хамрагдсан байна | 2024 оны 4 дүгээр сарын 2-ний өдрөөс 5 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинээч бэлтгэх, чадавхжуулах 4 өдрийн сургалтад хамрагдсан.<br>Гэрчилгээний дугаар -58 | | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭТБГ-ын АЛШТХ-ийн мэргэжилтэн ........ А.Баярзаяа ........ 2024.12.05 м

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)

55